

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны ... дугаар
сарын ...-ны өдөр

Дугаар..

Улаанбаатар
хот

Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журам батлах тухай

Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.8 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээлийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, эргэн төлүүлэх, сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох журам”-ыг хавсралтаар баталсугай.

2.Журмыг хэрэгжүүлэх бэлтгэл ажлыг хангах, хэрэгжилтийг зохион байгуулах, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай.

Гарын үсэг

**СУРАЛЦАГЧИЙН СУРГАЛТЫН ТӨЛБӨР, АМЬЖИРГААНЫ ЗАРДАЛД
ЗОРИУЛАН ОЛГОХ ХӨНГӨЛӨЛТТЭЙ, ЭРГЭН ТӨЛӨГДӨХ НӨХЦӨЛТЭЙ
ЗЭЭЛИЙН УЛСЫН ТӨСВИЙН ОРОЛЦООТОЙ ЭХ ҮҮСВЭРИЙГ БҮРДҮҮЛЭХ,
ЭРГЭН ТӨЛҮҮЛЭХ, СУРГАЛТЫН ЗЭЭЛИЙГ ХӨНГӨЛӨХ, ЧӨЛӨӨЛӨХ,
ХҮЧИНГҮЙ БОЛГОХ ЖУРАМ**

НЭГ. Нийтлэг үндэслэл

1.1. Монгол Улсын болон гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчийн сургалтын төлбөр, амьжиргааны зардалд зориулан олгох хөнгөлөлттэй, эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл /цаашид "сургалтын зээл" гэх-/ ийн улсын төсвийн оролцоотой эх үүсвэрийг бүрдүүлэх, суралцагчийн сургалтын зээлийг эргэн төлүүлэх, хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгоход энэхүү журмыг мөрдөнө.

1.2. Энэхүү журам нь Монгол Улсын болон гадаад улсын дээд боловсролын сургалтын байгууллагад Засгийн газраас баталсан журмын дагуу бакалавр, магистр, докторын боловсролыг эзэмшихээр элсэж, зохих журмын дагуу Боловсролын зээлийн сангаас сургалтын зээл авсан Монгол Улсын иргэнд хамаарна.

1.3. Энэхүү журмын дагуу зээл олгосон суралцагчийн сургалтын зээлийг хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох асуудлыг Засгийн газар хэлэлцэж шийдвэрлэнэ.

1.4. Суралцагчийн сургалтын зээлийн мэдээллийг Монгол Улсын зээлийн мэдээллийн санд бүртгэх үйл ажиллагааг Боловсролын зээлийн сан хариуцан зохион байгуулна.

ХОЁР. Сургалтын зээлийн санхүүгийн эх үүсвэр

2.1. Суралцагчид олгох сургалтын зээл нь Засгийн газрын тусгай сангийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан эх үүсвэрээс бүрдэнэ.

2.2. Сургалтын зээлд шаардагдах зардлыг жил бүр улсын төсөвт тусгана.

2.3. Гадаадад суралцагчид олгоход баримтлах зээлийн хэмжээний нормативыг гадаад харилцааны харилцааны асуудал эрхэлсэн териин захиргааны төв байгууллагын судалгаа, саналыг харгалзан Засгийн газар тухайн улсын иргэдийн амьжиргааны түвшинтэй уялдуулан ялгавартайгаар жил бүр тогтооно.

2.4. Гадаадад суралцагчийн сургалтын төлбөрт суралцаж буй сургуулиас нь нэхэмжилсэн хичээлийн багц цаг /кредит/-ийн төлбөр, эруул мэндийн даатгал, гадаад суралцагчийн хураамж, хоол, дотуур байр, номын сангийн үйлчилгээний төлбөр, бусад төлбөр, хураамжийг оруулан тооцно.

ГУРАВ. Зээлийн эргэн төлөлт

3.1. Суралцагчид энэхүү журам, Засгийн газраас баталсан журмын дагуу сургалтын зээл олгоно.

3.2. Суралцагч нь Боловсролын зээлийн сантай сургалтын зээлийн гэрээ байгуулна.

3.3. Энэ журмын 3.2-т заасан сургалтын зээлийн гэрээний загварыг боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран батална.

3.4. Боловсролын зээлийн сан нь суралцагчтай байгуулсан гэрээний биелэлтийг хариуцан, зээлийг тогтоосон хугацаанд эргэн төлүүлж, хөрөнгийг улсын төсөвт төвлөрүүлнэ.

3.5. Сургалтын зээлээр суралцагч сургуулиа төгссөний дараа Боловсролын зээлийн санд заавал бүртгүүлнэ.

3.6. Сургалтын зээлээр суралцан төгсөгч тогтоосон хугацаанд бүртгүүлээгүй тохиолдолд торгууль төлөх бөгөөд торгуулийн хэмжээг энэ журмын 3.3-т заасан гэрээнд тусгана.

3.7. Торгууль, алдангийн хувь, хэмжээг боловсролын болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн хамтран тогтооно.

3.8. Сургалтын зээлээр суралцан төгсөгч нь дипломын хуулбар, хөдөлмөр эрхэлж буйгаа нотолсон баримт бичиг, орлогын эх үүсвэр, хэмжээг Боловсролын зээлийн санд мэдэгдэн сургалтын зээлийн эргэн төлөлтийн хэмжээ, хугацааг тохирно.

3.9. Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцсан суралцагчийн зээлийг эргэн төлөх хугацаа нь сургалтын зээлээр суралцсан хугацаанаас ихгүй байна.

3.10. Суралцагч сургуулиа төгссөнөөс хойш Монгол Улсад ажиллаж байгаагаа Боловсролын зээлийн санд бүртгүүлсэн тохиолдолд зээлийн эргэн төлөлтийг 1 хүртэл жилээр түдгэлзүүлж болно.

3.11. Сургалтын зээлийн эргэн төлөлтийн хугацаа нь тухайн суралцагчийн сургууль төгссөнөөс хойш 10 жилээс ихгүй байна.

3.12. Энэ журмын 3.8-д заасан хугацаанд зээлийг бүрэн төлж барагдуулаагүй суралцагчид төлөөгүй үнийн дүнгээс хамаарч алданги тооцно. Алдангийн хэмжээг энэ журмын 3.3-т заасан гэрээнд тусгана.

3.13. Сургалтын зээл нь зээлийг эргэн төлөгдөх гэрээнд заасан хугацаанд хүүгүй байна.

3.14. Сургалтын зээлийн эргэн төлөлтийн хэмжээ нь зээлдэгчийн цалин болон бусад орлогын 50-иас дээш хувийг эзэлж байвал энэ журмын 3.11-д заасан хугацааг 5 хүртэлх жилээр сунгаж болно.

3.15. Суралцагчийн сурлагын үнэлгээ хангалтгүй байсны улмаас сургуулиас хасагдсан, чөлөөлөгдсөн, хүндэтгэх шалтгаангүйгээр суралцахаа зогсоосон тохиолдолд сургалтын зээлийн санхүүжилтийг зогсоож, уг асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

3.16.Энэ журмын 3.15-т заасан "хүндэтгэн үзэх шалтгаан" гэдэгт суралцагч хүндээр өвчилсөн, хүүхэд төрүүлсэн, хорио цээрийн дэглэм тогтоогдсон, байгалийн болон нийтийг хамарсан гамшиг тохиолдсон зэрэг өөрөөс нь үл хамаарах шалтгаанаар суралцах боломжгүй байсан нөхцөл байдлыг ойлгоно.

ДӨРӨВ. Зээлээс хөнгөлөх, чөлөөлөх, хүчингүй болгох

4.1.Монгол Улсын дээд боловсролын сургалтын байгууллагад суралцаж эзэмшсэн мэргэжлээрээ Монгол Улсад тасралтгүй 3 жил ажиллаж, нийгмийн даатгал төлсөн тохиолдолд сургалтын зээлийн үлдэгдлийн 50 хувийг хөнгөлнө.

4.2.Эзэмшсэн мэргэжлээрээ Монгол Улсад болон эрх бүхий байгууллагын шийдвэр, зөвшөөрлөөр эх орноо төлөөлөн гадаадад 5-аас доошгүй жил ажиллаж, нийгмийн даатгал төлсөн тохиолдолд сургалтын зээлээс чөлөөлнө.

4.3.Суралцаж байх хугацаандaa болон энэ журмын 3.8-д заасан хугацаанд хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан, нас барсан суралцагчийн сургалтын зээлийг хүчингүй болгоно.

4.4.Суралцагч нь энэ журмын 4.1-4.2-т заасан болзлыг хангасан нотлох баримтыг Боловсролын зээлийн санд ирүүлж, зээлийн хөнгөлөлт эдлэх, чөлөөлөгдөх хүсэлтээ гаргана.

4.5.Энэ журмын 4.3-т заасан нөхцөл үүссэн суралцагчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, асран хамгаалагч, гэр булийн гишүүн нь холбогдох нотлох баримтыг бүрдүүлэн сургалтын зээлийг хүчингүй болгох хүсэлтийг Боловсролын зээлийн санд гаргаж, шийдвэрлүүлнэ.

4.6.Сургалтын зээлээр суралцан төгсөгчийн ажилласан жилийг тогтоох зорилгоор Боловсролын зээлийн сан нь хөдөлмөрийн асуудал хариуцсан төрийн захиргааны төв байгууллагатай хамтран ажиллана.

4.7.Хөгжлийн бэрхшээлтэй төгсөгч 1-ээс доошгүй жил ажиллаж, нийгмийн даатгал төлсөн тохиолдолд сургалтын зээлээс чөлөөлнө.

ТАВ. Бусад

5.1.Энэ журмын хэрэгжилт, авч хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага жил бүрийн 12 дугаар сард багтаан Засгийн газарт тайлагнана.

5.2.Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, Боловсролын зээлийн сан нь суралцагчийн сургалтын явц, гэрээний биелэлтэд жил бүр хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, шаардагдах арга хэмжээг авч ажиллана.

5.3.Энэ журамд заасны дагуу сургалтын зээлээс хөнгөлөгдөх, чөлөөлөгдөх, хүчингүй болгуулах суралцагч нь холбогдох баримт бичгийг бүрдүүлэн Боловсролын зээлийн санд хүлээлгэн өгнө.

5.4.Суралцагч нь гэрээнд заасан хугацаанд суралцаж төгсөөгүй, зээлээ хугацаандaa төлөөгүй тохиолдолд Боловсролын зээлийн сангаас хууль, хяналтын байгууллагад нэхэмжлэл гарган сургалтын зээлийг эргэн төлүүлэх арга хэмжээг авна.